

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт .....	11
3.6 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.7 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	
4.1 Залруулсан алдаа .....	
4.4 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	Error! Bookmark not defined.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ИНЕГ	Иргэний нисэх ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэх үндэсний төв
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64000 Цамбагаараа Бас, Жаргалант сум, Ховд  
Утас: 978-70433061, Факс: 978-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН  
ДАРГА Г.ЖАРГАЛ ТАНАА

2022.03.14 № 2/120  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хуульд заасны худалдан авах ажиллагааг дагуу зохион байгуулаагүй, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гаргасан, санхүүгийн тайланд тусгасан, нотлох баримтгүй томилолтын мөнгө олгосон, шатахууны худалдан авалтын хөнгөлөлтийг орлогоор бүртгээгүй, ө баримтгүй бараа материалын худалдан авалт хийсэн, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд," 45.1-д "Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх",

"Үнэлгээ ба хуваарилалт", "толилуулга", "эрх ба үүрэг", "оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>199,056,574.74</u>	<u>206,017,727.96</u>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	33,553,691.74	37,238,751.01
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	33,553,691.74	37,238,751.01
3121	<b>Төгрөг</b>	33,553,691.74	37,238,751.01
31213	Арилжааны банк дахь харилцах	33,553,691.74	37,238,751.01
33	<b>АВЛАГА</b>	7,937,077.90	2,643,322.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,480,909.09	-
33401	Дансны авлага /ТӨҮГ/	6,456,168.81	2,273,022.81
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		370,299.41
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	157,565,805.10	166,135,654.73
354	<b>Хангамжийн материал</b>	157,565,805.10	166,135,654.73
35420	Аж ахуйн материал	94,307,470.50	110,327,010.22
35440	Түлш, шатах тослох материал	63,258,334.60	47,596,194.32
35470	Бусад хангамжийн материал		8,212,450.19
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u>15,111,286,636.03</u>	<u>15,210,876,831.37</u>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	15,111,286,636.03	15,210,876,831.37
392	<b>Биет хөрөнгө</b>	1,847,926,576.97	1,947,923,830.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,295,703,347.77	4,411,461,187.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,320,278,067.00)	(3,411,347,726.11)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	661,209,220	839,623,820
39204	Хуримтлагдсан элэгдэл	(477,511,465.35)	(497,922,074.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,563,844,958.82	3,580,203,150.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,901,994,859.12)	(3,002,116,847.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,144,920.00	85,656,369.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,121,291.25)	(66,246,519.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,410,801.36	55,108,426.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,480,988.26)	(46,495,955.72)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	13,263,360,059.06	13,262,953,000.71
39301	Программ хангамж	73,073,929.08	73,073,929.08
39302	Хуримтлагдсан элэгдэл	(69,611,870.02)	(70,018,928.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,259,898,000	13,259,898,000
394	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	-	16,695,000
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		16,695,000
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u>15,310,343,210.77</u>	<u>15,433,589,559.33</u>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	500,000	480,654.05
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	500,000	480,654.05
413	<b>Өглөг</b>	500,000	480,654.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	20,000	-
4136	<b>Бусад өглөг</b>	480,000	480,654.05
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	480,000	-
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		64,320.59
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		416,333.46
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u>15,309,843,210.77</u>	<u>15,433,108,905.28</u>

51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	15,309,843,210.77	15,433,108,905.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,338,307,564.24	13,316,428,264.94
51101	Өмч: - төрийн	13,259,898,000	13,259,898,000
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	78,409,564.24	56,530,264.94
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,358,372,960.18	1,503,517,953.99
51210	Өмнөх үеийн үр дүн	1,181,742,149.61	-
51220	Тайлант үеийн үр дүн	176,630,810.57	1,503,517,953.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	613,162,686.35	613,162,686.35
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>15,310,343,210.77</b>	<b>15,433,589,559.33</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,567,512,289.57</b>	<b>2,247,367,791.30</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>533,073,604.38</b>	<b>243,956,723.81</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>515,591,137.77</b>	<b>56,656,899.32</b>
120007	Навигацийн орлого	58,320,405.84	35,571,563.03
120008	Монгол банкны ашиг	443,382.22	-
120009	Бусад орлого	23,115	1,000,000
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	456,804,234.71	20,085,336.29
121	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>17,482,466.61</b>	<b>187,299,824.49</b>
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	17,482,466.61	187,299,824.49
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,034,438,685.19</b>	<b>2,003,411,067.49</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,034,438,685.19</b>	<b>2,003,411,067.49</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,034,438,685.19	2,003,411,067.49
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,390,881,479.00</b>	<b>2,102,222,797.49</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,390,881,479.00</b>	<b>2,102,222,797.49</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,374,809,479.00</b>	<b>2,092,081,797.49</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,197,349,536.42</b>	<b>1,119,967,535.78</b>
210101	Үндсэн цалин	749,249,184.42	685,570,751.93
210102	Нэмэгдэл	269,550,352	268,691,783.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	178,550,000	165,705,000
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>163,140,854.44</b>	<b>157,077,066.75</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	163,140,854.44	157,077,066.75
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>95,122,454.42</b>	<b>98,918,387.82</b>
210301	Гэрэл, цахилгаан	28,270,843.38	30,794,248.17
210302	Түлш, халаалт	65,062,069.22	66,143,639.65
210303	Цэвэр, бохир ус	1,789,541.82	1,980,500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>180,888,514.64</b>	<b>180,014,515.88</b>
210401	Бичиг хэрэг	5,893,962.31	4,786,430.27

210402	Тээвэр, шатахуун	99,336,196.12	96,259,199.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,818,109.41	8,895,729.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,516,323.80	4,286,849.58
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	62,323,923	62,888,852.78
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>13,920,909.29</b>	<b>16,713,818.18</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,920,909.29	16,713,818.18
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>197,177,770.29</b>	<b>136,663,633.14</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,142,157.23	19,166,282.77
210604	Урсгал засвар	179,035,613.06	117,497,350.37
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>69,916,146.78</b>	<b>47,167,505.52</b>
210702	Дотоод албан томилолт	67,032,055.28	47,167,505.52
210703	ХАруул хамгаалалт	2,884,091.50	2,897,454.55
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>151,892,331.05</b>	<b>98,247,424.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,100,000	2,163,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	122,960	113,560
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	131,542,098.41	64,161,364.90
210813	Бусад зардал /ТӨҮГ/	18,127,272.64	31,809,499.91
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>305,400,961.67</b>	<b>237,311,909.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,457,508.76	4,657,940.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000	1,500,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	299,443,452.91	231,153,969.53
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,072,000</b>	<b>10,141,000</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>16,072,000</b>	<b>10,141,000</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,072,000	10,141,000
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>176,630,810.57</u></b>	<b><u>145,144,993.81</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>176,630,810.57</u></b>	<b><u>145,144,993.81</u></b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18		15,231,443,646.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18	78,409,564.24	15,309,853,210.77
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18	78,409,564.24	15,309,853,210.77
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18	78,409,564.24	15,309,853,210.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-	-

D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	13,259,898,000	613,162,686.35	1,358,382,960.18	78,409,564.24	15,309,853,210.77
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				(21,879,299.30)	(21,879,299.30)
D08	Тайлант үеийн үр дүн			145,144,993.81	-	145,144,993.81
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	13,259,898,000	613,162,686.35	1,503,517,953.99	56,530,264.94	15,433,108,905.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<u>1,899,847,168.01</u>	<u>1,953,197,650.16</u>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,899,847,168.01	1,953,197,650.16
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,899,847,168.01	1,953,197,650.16
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,859,565,000	1,941,191,104
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,859,565,000	1,941,191,104
120009	Бусад орлого	20,412,680.36	9,470,398
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	19,869,487.65	2,536,148.16
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<u>1,902,344,093.45</u>	<u>1,970,102,145.14</u>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,902,344,093.45	1,970,102,145.14
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,902,344,093.45	1,970,102,145.14
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,197,349,536.42	1,119,967,535.78
210101	Үндсэн цалин	749,249,184.42	685,570,751.93
210102	Нэмэгдэл	269,550,352	268,691,783.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	178,550,000	165,705,000
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	163,140,854.44	157,077,066.75
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	163,140,854.44	157,077,066.75
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,606,839.98	50,606,291.23
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	51,606,839.98	50,606,291.23
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	329,958,618	387,099,736
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	169,324,250	198,208,010
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	160,634,368	188,891,726
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,288,244.61	255,351,515.38
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	144,036,227.84	131,935,973.38
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	7,279,000	7,279,000
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	8,973,016.77	116,136,542
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<u>(2,496,925.44)</u>	<u>(16,904,494.98)</u>

8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b> (8)=(3)+(6)+(7)	(2,951,751.98)	3,685,059.27
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	36,505,443.72	33,553,691.74
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	33,553,691.74	37,238,751.01

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		33,553,691.74
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,999,869,600	1,949,512,590.89
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,999,869,600	1,949,512,590.89
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,987,248,300	1,945,971,590.89
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,086,364,672	1,119,967,535.78
210101	Үндсэн цалин	1,086,364,672	685,570,751.93
210102	Нэмэгдэл		268,691,783.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт		165,705,000
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	180,350,100	157,077,066.75
210201	Тэтгэврийн даатгал	115,939,500	101,878,850.16
210202	Тэтгэмжийн даатгал	12,882,200	11,376,744.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,187,900	20,225,858.95
210204	Ажилгүйдлийн даатгал	2,576,400	2,154,180.87
210205	Эрүүл мэндийн даатгал	25,764,100	21,441,432.43
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	102,110,000	115,620,844.40
210301	Гэрэл, цахилгаан	32,740,000	33,727,344.40
210302	Түлш, халаалт	67,295,000	79,991,050
210303	Цэвэр, бохир ус	2,075,000	1,902,450
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	118,950,900	128,720,601.03
210401	Бичиг хэрэг	4,851,500	6,560,250.00
210402	Тээвэр, шатахуун	96,997,300	107,870,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,156,000	8,658,316.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,338,000	3,962,541.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,608,100	1,669,494.00
2105	<b>Нормативт зардал</b>	17,184,000	13,440,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,184,000	13,440,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	158,978,900	306,074,279.79
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	20,006,472.00
210604	Урсгал засвар	158,978,900	286,067,807.79
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	46,762,400	32,377,500
210702	Дотоод албан томилолт	46,762,400	32,377,500
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	68,195,000	65,840,509.14

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,425,000	2,100,000
210803	Даатгалын үйлчилгээ	7,280,000	7,279,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,101,000	1,108,725
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,900,000	1,000,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,011,000	33,011,026.14
210807	Газрын төлбөр	21,228,000	21,228,198
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250,000	113,560
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,500,000	6,853,254
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000	5,433,254
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000	1,420,000
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12,621,300	3,541,000
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,621,300	3,541,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,621,300	3,541,000
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,999,869,600	1,953,197,650.16
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,999,869,600	1,953,197,650.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,961,869,600	1,941,191,104
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,000,000	12,006,546.16
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		33,553,691.74
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		37,238,751.01
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	54	54
620001	Удирдах ажилтан	2	2
620002	Гүйцэтгэх ажилтан	52	52

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, худалдан авах ажиллагаа, анхан шатны баримт, зардалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 03 дугаар сарын 06-наас 2022 оны 03 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн ч аудитад шаардлагатай баримт материалыг 2022 оны 03 дугаар сарын 4-ний өдөр ирүүлсэн болно.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймаг дахь Нисэх буудал “Зорчигч, үйлчилгээ, нисэхийн аюулгүй байдлыг хангаж ажиллах” эрхэм зорилтыг дэвшүүлэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа Ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ИНЕГ-ын дотоод аудитын албанаас 2021 оны 9 дүгээр сарын 30-аас 10 дугаар сарын 08-ны хооронд 2020-2021 оны үйл ажиллагаанд дотоод аудитын хяналтыг зайнаас хэрэгжүүлсэн ч үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогын 1,953.2 сая төгрөгөөс 0.5 хувиар тооцон 9.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 15,433.6 сая төгрөгөөр болж 116.3 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд 33.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 37.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй болж өмнөх 11 хувиар өссөн байна

Авлага оны эхэнд 7.9 сая төгрөг байсан бол оны эцэст 2.6 сая төгрөг болж 5.3 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 166.1 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр нэмэгдэж тайлант онд 355.1 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 346.5 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Тайлант оны эхэн болон оны эцэст 0.5 сая төгрөг өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 15,309.8 сая төгрөг байсан оны эцэст 15,433.1 сая төгрөг тайлант онд 123.3 төгрөгөөр өссөн нь тайлант үед ашигтай ажилласантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,223.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,223.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Иргэний нисэхийн Үндэсний төвөөс Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны төсвийг анх 1,992.1 сая төгрөгөөр баталж, 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр 1,999.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1,999.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1,961.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 38.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,814.0 сая төгрөг, ИНҮТ-өөс авто гараашны их засвар, аэродромын тэмдэгт тэмдэгтийн санхүүжилт 127.2, аймгийн ОНХС-аас 3.3, бууралт хөөрөлтийн орлого 2.5, тендерийн бичиг баримтын орлого 0.03 сая төгрөг нийт 1,953.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,949.5 сая төгрөгийг зарцуулж 37.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,949.5 сая төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь нормативт зардлыг 3.7, урсгал шилжүүлгийг 9.1 сая төгрөгөөр хэмнэж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 10.3, байр ашиглалттай холбоотой зардлыг 13.5, хангамж бараа материалын зардлыг 9.8, эд хогшил, урсгал засварын зардлыг 147.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулах шаардлагатай дараах асуудлууд байна.

Албан хаагчийн үр дүнгийн нэмэгдэл, утасны төлбөр олголт, байгууллын данс бүртгэлд байгаа ажилчдын 6 орон сууцны асуудлыг нарийвчлан хянах шаардлагатай байна.

### 3.7 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.8.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа оруулсан, 12 мэдээллийг оруулаагүй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу зарлагын ажил гүйлгээг мэдээлсэн ч зарлагын 4 ажил гүйлгээг дансны сайтад байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудын нарийвчлан хянаж үзэх шаардлагатай байна. Үүнд.

1. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа ажилчдын 6 орон сууцны гэрчилгээ хаана байгаа нь нотлогдохгүй байгаа тус хөөн хянах
2. 2021 оны түлээ нүүрс бусад аж ахуйн бараа материалын худалдан авалт, зарцуулалт,
3. Байгууллагын ажилчдын цалин, үр дүнгийн урамшуулал олголт,
4. Шатахууны зарцуулалтыг авч үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 317.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 92.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 214.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### 4.1.1 Төлбөрийн акт

1. Томилолтоор ажилласныг нотлох анхан шатны баримтгүй ажилчдын нэр дээр томилолтын мөнгөн гаргаж, тушаал шийдвэргүй нэмэгдэл цалин бодож 6.4 сая төгрөгийг олгосон алдаа зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн хуулийн заалт, аудитын "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: дээрх алдаа зөрчилтэй холбоотой 6.4 сая төгрөгийн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Шатахуун нийлүүлэгч байгууллагаас худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулалд олгосон 3.2 сая төгрөгийн шатахууныг бараа материалын тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар зарцуулсан зөрчил илэрсэн нь үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" , Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д "Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана", дүрмийн 17-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны хөнгөлөлттэй холбоотой 3.2 сая төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Булган сумын Нисэхийн онгоцны техникч аймгийн Нисэх буудлын онгоцны техникч ээлжийн амралттай хугацаанд тухайн үед томилолтоор ажилласан хугацааны томилолтын 1.5 сая төгрөгийг олгоогүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Иргэний нисэхийн ерөнхий газрын "хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.7.1-д "ажилтны баталсан удирдамжийн дагуу орон нутагт томилолтоор ажиллуулна", 4.7.2-д "ажилтныг томилолтоор ажиллуулахад эрх бүхий байгууллагын баталсан тарифын дагуу томилолтын зардлыг тооцож олгоно" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

## **4.2 Албан шаардлага**

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус баримтаар 21.6 сая төгрөгийн томилолтын мөнгө олгосон,
2. Бэлтгэн нийлүүлэгч байгууллага, хувь хүний данс руу төлбөрийг төлсөн ч уг бараа материалыг бүрэн нийлүүлэгдсэн эсэх нь тодорхой бус 60.8 сая төгрөгийн зарлага гаргасныг нотлох боломжгүй,
3. Тайлант онд ямар байгууллагаас нийлүүлэгдсэн хэчнээн хэмжээний ачааг тээвэрлэсэн нь тодорхой бус, 6.6 сая төгрөгийг нотлох баримтгүй, үнс зайлуулсны ажлын хөлс 3.1 сая төгрөг олгохдоо ажилчдын нэрээр дамжуулан гаргасан, хэчнээн тонн үнсийг хэдэн удаа, хэдий хугацаанд зөөж тээвэрлэх талаар гэрээ байгуулаагүй,

4. Дотоод хяналтын багийн хийх ажлын төлөвлөгөөнд санхүүгийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлууд тусгагдаагүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.4.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд бараа материал худалдан авахдаа бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан 26.3 сая төгрөгийн зардлуудыг баримтжуулахдаа е баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахгүй, гаргахгүй байх,

##### 4.4.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд шатахуун, нүүрс худалдан авахдаа холбогдох хуульд заасан ажиллагааны журам мөрдөөгүй, Тендерийн урилга нээлттэй мэдээлснийг нотлох баримтгүй, 103.4 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан, нүүрсний тээврийн үйлчилгээ хийдэггүй аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан, эд хариуцагчийн нэрээр мөнгө гаргаж 72.0 сая төгрөгийн нүүрс авсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;" 45.1-д "Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэвших,

##### 4.4.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үр дүнгийн урамшууллыг сар бүр байгууллагын дарга, нягтлан бодогчид олгосон, сар бүр даргад утасны төлбөрт 30.0 мянган төгрөг, 2021 онд үр дүнгийн урамшуулал, утасны төлбөрт нийт 12.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь ИНЕГ-ын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/803 тоот тушаалаар баталсан " Иргэний нисэхийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.2.1-д

"ажилтны ажлын үр дүнг үнэлж, үндсэн цалингийн 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний үр

Ховд аймаг дахь Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэвших,

**4.4.3 Зардалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Үр дүнгийн урамшууллыг сар бүр байгууллагын дарга, нягтлан бодогчид олгосон, сар бүр даргад утасны төлбөрт 30.0 мянган төгрөг, 2021 онд үр дүнгийн урамшуулал, утасны төлбөрт нийт 12.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь ИНЕГ-ын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/803 тоот тушаалаар баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.2.1-д "ажилтны ажлын үр дүнг үнэлж, үндсэн цалингийн 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний үр дүнгийн нэмэгдлийг сар бүр олгож болно", Засгийн газрын 2016 оны 47 дугаар тогтоолын 2-д "албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажлын үр дүнг бодитой дүгнэж урамшууллыг олгох, утасны төлбөрийг олгодог асуудлыг зогсоох

**4.4.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Байгууллагын данс бүртгэлд байгаа 6 орон сууцтай боловч зарим ажилчид нь тэтгэвэрт гарсан өөр ажилд шилжсэн, байгууллагад байраа хүлээлгэн өгөөгүй, байр эзэмшиж байгаа ажилчидтай гэрээ байгуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь ИНЕГ-ын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/803 тоот тушаалаар баталсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.5.7-д "Ажилтанд байгууллагын мэдлийн орон сууцыг түр хугацаагаар эзэмшүүлж болно. Энэ тохиолдолд Захиргаа хариуцсан нэгжээс тухайн ажилтантай орон сууц түр хугацаагаар эзэмшүүлэх гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Холбогдох журамд заасны дагуу гэрээ байгуулах, ажлаас гарсан ажилчдын байрны асуудлыг шийдвэрлэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд аймаг дахь Нисэх буудал	8	317.3	-	-	3	11.1	1	92.1	4	214.1

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР  
 АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН  
 ТАЙЛАНГ БИЧСЭН  
 АХЛАХ АУДИТОР: Д.НАРАНТУУЛ



Аудитын код: ХОА-2022/03/НА-СТА-ТӨА

14